



211

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 09 сарын 20 өдөр

Дугаар A/589

Улаанбаатар хот

Г Боловсролын зээлийн сангийн
санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөр болон амьжиргааны зардлын зээл олгох журам", Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны "Журам батлах тухай" 11 дүгээр тушаалаар батлагдсан "Сургалтын төрийн сангийн санхүүжилтээр гадаад магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг шалгаруулах журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Баатаржав овогтой Нарангэрэл, Австрали улс, UNSW их сургууль, Нийгмийн эрүүл мэнд мэргэжлээр, 2 жил, Нямхүү овогтой Төмөр, Австрали улс, UNSW их сургууль, Хууль эрх зүй мэргэжлээр магистрантурт 1 жил, Лхагвасүрэн овогтой Уянга, Япон улс, University of Kyoto их сургууль, Бизнесийн технологи мэргэжлээр магистрантурт 2 жил, Гомбо овогтой Бумцэнд, АНУлс, Duke University их сургууль, Уул уурхай мэргэжлээр магистрантурт 2 жил, Гантулга овогтой Буянцаал, АНУлс Пенсильваны их сургууль, Хуульч мэргэжлээр магистрантурт 2 жил Солтан овогтой Ахмед, АНУлс, Sent Louis University их сургууль, Ложистик мэргэжлээр магистрантурт 2 жил Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр тус тус суралцуулсугай.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, төлбөр, тооцоо хийхийг Боловсролын зээлийн сан /М.Ариунжаргал/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Олон улсын төсөл, хөтөлбөр гадаад хамтын ажиллагааны газар /Т.Ууганбаяр/-т тус тус даалгасугай.

САЙД

Ц.ЦОГЗОЛМАА

